

## МӨНГӨНИЙ ТОЙМ

2017 оны 10 дугаар сар

- Мөнгөний нийлүүлэлт 2017 оны 10 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 25.1%-иар өсч, өмнөх сараас 1.5%-иар буурч 14.5 их наяд төгрөг болов.
- Мөнгөний нийлүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийг өмнөх сартай харьцуулбал төгрөгийн хадгаламжаас бусад нь бууралттай байна.
- Нөөц мөнгө өмнөх сараас төдийлөн өөрчлөгдөөгүй буюу 3.1 их наяд төгрөг байна.
- Нийт хадгаламжийн байгууллагуудын зээлийн үлдэгдэл тайлант сард 34.8 тэрбум төгрөгөөр буурч, 13.4 их наяд төгрөг байна. Энэ нь “МИК ОССК” –д 178.8 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийн багцыг шилжүүлсэнтэй холбоотой. Нийт зээлийн 50.3 хувь нь хувийн хэвшилд, 49.0 хувь нь иргэдэд олгосон зээл байна.
- Хадгаламжийн байгууллагуудын нийт зээлийн 7.2 хувь нь хугацаа хэтэрсэн, 8.8 хувь нь чанаргүй зээл байна. Хугацаа хэтэрсэн зээлийн нийт зээлд эзлэх хувь өмнөх сараас 1.1 нэгж хувиар, чанаргүй зээлийнх 0.1 нэгж хувиар тус тус өсчээ.

## МӨНГӨ, САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

		2016		2017		
		12-р сар	3-р сар	6-р сар	9-р сар	10-р сар
<b>Инфляци</b>						
Улаанбаатар хотын	сарын	0.7	1.6	-0.6	0.5	0.4
	оны эхнээс	0.5	3.2	4.8	6.6	7.0
	жилийн	<b>0.5</b>	<b>3.0</b>	<b>3.5</b>	<b>6.6</b>	<b>8.2</b>
Суурь	сарын	0.3	0.7	0.1	0.8	1.1
	оны эхнээс	0.5	0.9	2.7	5.0	6.2
	жилийн	<b>0.5</b>	<b>2.8</b>	<b>4.7</b>	<b>5.9</b>	<b>7.4</b>
Улсын	сарын	0.6	1.2	-0.6	0.2	0.4
	оны эхнээс	1.1	3.0	4.1	5.3	5.7
	жилийн	<b>1.1</b>	<b>3.1</b>	<b>3.3</b>	<b>5.8</b>	<b>6.9</b>
<b>Мөнгө, санхүүгийн сектор</b>						
<b>Нөөц мөнгө, тэрбум ₮</b>		3,064.4	2,749.9	3,179.5	3,269.8	3,100.6
сарын өөрчлөлт, хувиар		-5.7	2.8	6.5	-0.9	-5.2
жилийн өөрчлөлт, хувиар		24.6	17.0	-9.8	5.6	5.9
<b>M2 мөнгө, тэрбум ₮</b>		12,158.6	12,260.2	13,484.1	14,749.7	14,520.7
сарын өөрчлөлт, хувиар		3.7	-0.6	3.8	1.5	-1.6
жилийн өөрчлөлт, хувиар		21.0	21.2	20.5	27.6	25.1
<b>Бусад хадгаламж, тэрбум ₮</b>		10,010.8	10,134.4	10,763.5	11,949.3	11,894.1
сарын өөрчлөлт, хувиар		2.2	-0.2	2.5	1.5	-0.5
жилийн өөрчлөлт, хувиар		19.7	18.8	16.9	25.3	24.9
<b>Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө, тэрбум ₮</b>		823.6	788.3	915.0	878.9	832.1
сарын өөрчлөлт, хувиар		7.1	-16.6	4.5	-2.3	-5.3
жилийн өөрчлөлт, хувиар		16.6	19.7	9.0	10.4	3.2
<b>Хад.байгууллагуудын зээлийн үлдэгдэл, тэрбум ₮</b>		12,422.7	12,678.5	12,903.1	13,421.4	13,386.6
сарын өөрчлөлт, хувиар		-2.3	0.8	1.5	1.2	-0.3
жилийн өөрчлөлт, хувиар		6.1	7.1	7.3	7.4	6.5
<b>Хад.байгууллагуудын чанаргүй зээлийн үлдэгдэл, тэрбум ₮</b>		1,051.7	1,035.5	1,132.3	1,169.5	1,173.8
сарын өөрчлөлт, хувиар		-9.9	-3.2	-2.2	-0.1	0.4
жилийн өөрчлөлт, хувиар		20.9	7.0	9.3	4.5	3.0
<b>Мөнгөний үржүүлэгч</b>		4.0	4.5	4.2	4.5	4.7
<b>Банк хоорондын зах</b>						
<b>Илүүдэл нөөц, сая төгрөгөөр</b>		-24.0	-58.7	-73.5	-56.1	-50.9
сарын өөрчлөлт, хувиар		50.3	-60.9	-127.5	-26.4	9.2
<b>Илүүдэл нөөц - Байнгын санхүүжилт</b>		-5,955.0	-24,819.1	-28,842.1	-45,500.1	-42,871.1
сарын өөрчлөлт, хувиар		81.4	-526.2	-963.0	-2,365.2	5.8
<b>Илүүдэл нөөц - ТБ-ны буцах санхүүжилт + ОН + ТБҮЦ</b>		530,470.2	895,349.6	1,604,933.3	1,931,172.7	1,812,517.9
сарын өөрчлөлт, хувиар		-40.0	75.5	24.5	19.0	-6.1
<b>Хүү (хувиар)</b>						
<b>Хадгаламжийн ЖДХ</b>		13.1	13.0	12.1	13.0	13.1
Хадгаламжийн бодит хүү*		12.6	10.0	8.6	6.3	4.9
<b>Зээлийн ЖДХ**</b>		19.7	20.2	20.3	19.9	19.9
Зээлийн бодит хүү*		19.2	17.2	16.8	13.2	11.7
<b>Ипотекийн зээлийн хүү</b>		10.3	10.3	10.2	10.1	10.3
<b>ТБҮЦ-ны ЖДХ</b>		14.5	14.0	12.9	12.0	12.0
<b>Бодлогын хүү</b>		14.0	14.0	12.0	12.0	12.0
<b>БХЗ-ын ЖДХ</b>		15.5	15.0	13.1	12.1	12.1

\* Улаанбаатар хотын хэрэглээний барааны үнийн индексээр тооцсон

\*\* Тухайн сард олгосон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү

### Мөнгөний нийлүүлэлт

Нийт M2 мөнгөний нийлүүлэлтийн 52.9%-ийг төгрөгийн хадгаламж бүрдүүлж байгаа бол 17.1%-ийг валютын хадгаламж, 14.6%-ийг төгрөгийн харилцах, 11.9%-ийг валютын харилцах, үлдсэн хувийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө бүрдүүлж байна.

M2 мөнгөний жилийн өсөлтийн түвшин 25.1%-д хүрч өмнөх сарынхаас 2.6 нэгж хувиар буурсан байна. Жилийн өсөлтийн дийлэнх хувийг төгрөгийн хадгаламж бүрдүүлсэн хэвээр байгаа бөгөөд өсөлтөд эзлэх хувь хэмжээ нь өмнөх сарынхаас 1.7 нэгж хувиар өсчээ. Харин валютын хадгаламжийн мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд үзүүлэх хувь хэмжээ өмнөх сараас 2.1 нэгж хувиар, төгрөгийн харилцахынх 1.5 нэгж хувиар буурав.

Өмнөх сараас M2 мөнгөний нийлүүлэлт 1.5% (228.6 тэрбум төгрөгөөр)-иар буурч 14.5 их наяд төгрөгт хүрсэн байна. Үүнээс M1 мөнгө 6.2% (173.9 тэрбум)-иар, бусад хадгаламж 0.5% (55.2 тэрбум)-иар тус тус буурав.


Бусад хадгаламжийн бүрэлдэхүүн хэсгүүдээс валютын хадгаламж 112.6 тэрбум төгрөгөөр, валютын харилцах 197.8 тэрбум төгрөгөөр тус тус буурсан бол төгрөгийн хадгаламж 255.2 тэрбум төгрөгөөр өсчээ. Энэ нь төгрөгийн гадаад валюттай харьцах ханш чангарсантай холбоотойгоор төгрөгийн хадгаламжийг илүүд үзэж буй явдал юм.

M1 мөнгөний бүрэлдэхүүн хэсгээс төгрөгийн харилцах 123.1 тэрбум төгрөгөөр, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 50.8 тэрбум төгрөгөөр буурсан байна.


Нийт хадгаламжийн 83.7%-ийг иргэдийн хадгаламж бүрдүүлж байна. Харин гадаад валютын хадгаламжийн нийт хадгаламжид эзлэх хувь 24.5%-д хүрч өмнөх сараас 1.5 нэгж хувиар буурчээ. Хэдийгээр эзлэх хувь бага зэрэг буурсан ч банкны салбарын пассивын долларжилт өндөр хэвээр байна.

Тайлант сард иргэдийн гадаад валютын хадгаламж өмнөх сараас 4.9%-иар, байгууллагын валютын хадгаламж 2.1%-иар, нийт дүнгээр 4.3%-иар буурсан байна.


Зураг 1. Мөнгөний нийлүүлэлтийн бүрэлдэхүүн (эх үүсвэрээр)



Зураг 2. M2 мөнгөний жилийн өсөлт



Зураг 3. Мөнгөний нийлүүлэлтийн сарын өөрчлөлт, тэрбум ₮



Зураг 4. Хадгаламжийн үлдэгдэл (иргэд, байгууллага)



### Гадаад, дотоод актив

M2 мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас нь авч үзвэл Төв банк болон хадгаламжийн байгууллагуудын гадаад цэвэр актив өмнөх сараас 12.8 тэрбум төгрөгөөр, дотоод цэвэр актив 216.2 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна. Гадаад цэвэр активын өөрчлөлтөд Төв Банкны гадаад цэвэр актив 146.0 тэрбум төгрөгөөр өсч, хадгаламжийн байгууллагуудынх 159.8 тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлөв. Энэ нь төгрөгийн ханшийн чангаралтаас үүдэн банкууд гадаад валютын позицыг богино байлгах сонирхолтой байгаагаар тайлбарлагдана. Харин дотоод цэвэр активын өөрчлөлтөд Төв Банкны дотоод цэвэр актив 315.2 тэрбум төгрөгөөр буурч, хадгаламжийн байгууллагуудынх 99.0 тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Нийт хадгаламжийн байгууллагуудын дотоод активаас Засгийн газраас авах цэвэр авлага 191.3 тэрбум төгрөгөөр, иргэдээс авах авлага 58.9 тэрбум төгрөгөөр буурсан бол хувийн байгууллагуудаас авах авлага 24.8 тэрбум төгрөгөөр, бусад санхүүгийн байгууллагынх 89.5 тэрбум төгрөгөөр тус тус өсчээ.


Тайлант сард нөөц мөнгө 3.1 их наяд төгрөг байгаа нь өмнөх сараас 169.2 тэрбум төгрөг буюу 5.2 хувиар буурсан байна. Нөөц мөнгөний 73.3 хувийг банкуудын Төв Банк дахь харилцах, 18.3 хувийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө, 8.5 хувийг банкуудын касс дахь мөнгө бүрдүүлж байна.

### Хадгаламжийн байгууллагуудын зээлийн үлдэгдэл


Хадгаламжийн байгууллагуудаас олгосон зээлийн үлдэгдэл өмнөх сараас 34.8 тэрбум төгрөгөөр буурч 13.4 их наяд төгрөг байна. Нийт зээлийн үлдэгдлийн жилийн өсөлт 7 хувь, иргэдэд олгосон зээлийн үлдэгдлийнх 18 хувь байгаа бол хувийн хэвшлийнх 2 хувиар буурсан байна. Энэ нь банкууд эрсдэл нь одоогоор харьцангуй бага байгаа цалин, тэтгэвэр зэрэг хэрэглээний зээлийг олгож чанаргүй зээлийн хувь өндөр бизнесийн зориулалттай зээлийг хумьж байгааг харуулж байна.

Нийт зээлийн үлдэгдлийн 50.3 хувийг хувийн хэвшилд, 49.0 хувийг иргэдэд, 0.7 хувийг бусад салбарт олгосон зээл бүрдүүлж байна.


Зураг 5. Төв Банк, хадгаламжийн байгууллагуудын гадаад, дотоод цэвэр актив



Зураг 6. Нөөц мөнгө




Зураг 7. Хадгаламжийн байгууллагуудын зээлийн үлдэгдэл, жилийн өсөлт



Хугацаа хэтэрсэн зээлийн нийт зээлд эзлэх хувь өмнөх сарынхаас 1.1 нэгж хувиар өсч 7.2 хувьд хүрсэн бол чанаргүй зээлийн эзлэх хувь өмнөх сарынхаас өөрчлөлтгүй 8.8 хувь байна. Хугацаа хэтэрсэн зээлийн 85.0 хувийг, чанаргүй зээлийн 79.3 хувийг хувийн хэвшилд олгосон зээл эзэлж байна.


Зураг 8. Хадгаламжийн байгууллагуудын хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээл



### Мөнгөний зах

Тухайн сард банк хоорондын мөнгөний захаар дамжуулан банкууд 644.3 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн байна. Үүний 39.1 хувийг Төв банкны үнэт цаасны арилжаа шууд арилжаа, 26.4 хувийг овернайт зээл, 12.0 хувийг ТБҮЦ-ны репо арилжаа, 11.3 хувийг ЗГҮЦ-ны арилжаа, 11.1 хувийг банк хоорондын хадгаламж тус тус бүрдүүлжээ.

Зураг 9. Банк хоорондын захын арилжааны дүн, хүү




Банкууд заавал байлгах нөөцийн шаардлагыг хангах, тооцоо, гүйлгээний зорилгоор 2017 оны 9 дүгээр сарын 27-ны өдрөөс 10 дугаар сарын 10-ны өдрийн хооронд 1350.3 тэрбум, 2017 оны 10 дугаар сарын 11-ний өдрөөс 24-ний өдрийн хооронд 1362.0 тэрбум төгрөгийг Монголбанк дахь төгрөгийн харилцахад, дээрх хугацаанд харгалзан 612.5 тэрбум болон 614.7 тэрбум төгрөгтэй тэнцэх валютыг валютын харилцах дансанд тус тус байршуулжээ.


### Хүү

Тайлант сард төгрөгийн шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх сарынхаас өөрчлөлтгүй буюу 19.9%, үлдэгдэлд жигнэсэн хүү 0.2 нэгж хувиар буурч 18.2%-д тус тус хүрчээ. Зээлийн үлдэгдлийг хугацаагаар нь ангилан харвал 4 сараас 36 сар хүртэлх хугацаатай зээлийн хүүнүүд 20% орчимд байгаа бол 3 сар хүртэлх 17% орчимд, 37-60 сар хүртэлх 18 хувь байна. Харин 60 сараас дээш хугацаатай зээлийн хувьд 13% байна. Шинээр олгосон зээлийн хувьд 4-18 сар хүртэлх хугацаатай зээлийг 21% орчимд олгосон байхад 19-60 сар хүртэлх хугацаатай зээлийн хувьд 19%, 60-аас дээш 17%, 3 сар хүртэлхийн 18% орчимд олгосон байна. Сектороор ангилан харвал хувийн байгууллагад олгосон зээлийн хүү нь иргэдэд олгосон зээлийн хүүнээс бага байгаа нь харагдаж байна. Валютын зээлийн хувьд тухайн сард шинээр олгосон зээлийн хүү 9.8%, харин зээлийн үлдэгдлээр жигнэсэн хүү 11.3% байгаа нь өмнөх сарынхаас тус бүр 1.8 болон 0.1 нэгж хувиар буурсан үзүүлэлт байна. Шинээр олгосон зээлийн хүү ийнхүү буурсан нь бага хүүтэй

Зураг 10. Зээлийн жигнэсэн дундаж хүү (төгрөг)



Зураг 11. Хадгаламжийн жигнэсэн дундаж хүү (төгрөг)



гадаад эх үүсвэрийн зээл хувийн хэвшилд олгогдсоноос шалтгаалсан байна.

Төгрөгийн хадгаламжийн үлдэгдлээр жигнэсэн хүү өмнөх сараас 0.1 нэгж хувиар өсч 13.1%, тухайн сард татсан хадгаламжийн жигнэсэн хүү 0.6 нэгж хувиар өсч 13.0%-д тус тус хүрчээ. Гадаад валютын хадгаламжийн хувьд үлдэгдлээр жигнэсэн хүү өмнөх сараас 0.2 нэгж хувиар буурч 5.2%, шинээр татсан хадгаламжийн хүү 0.2 нэгж хувиар өсч 5.3% болжээ.

Шинээр татсан хадгаламжийн хүү нь үлдэгдлээр жигнэсэн хүүнээс бага байгаа нь хадгаламжийн хүү ерөнхийдөө буурч буйг илэрхийлж байна. Ялангуяа энэ байдал урт хугацаатай хадгаламжууд дээр илүү түлхүү ажиглагдаж байна. Энэ нь цаашид бодлогын хүү буурна гэсэн хүлээлтээр тайлбарлагдаж болно.

### Валютын ханш


2017 оны 10 дугаар сарын байдлаар Монголбанкнаас зарласан төгрөгийн ам.доллартай харьцах дундаж ханш өмнөх сарынхаас 0.2 хувиар суларч 2458.7 төгрөг байв. Тухайн сарын хамгийн өндөр ханш нь 2465.3 төгрөг байсан бол хамгийн бага нь 2455.1 төгрөг байв. Харин сарын эцсийн ханш 2456.2 буюу өмнөх сарынхаас 0.3 хувиар чангарсан байна.

БНХАУ-ын юаньтай харьцах дундаж ханш өмнөх сарынхаас 0.7 хувиар чангарч 371.0 төгрөг байв. Тухайн сарын хамгийн өндөр ханш нь 374.1 төгрөг байсан бол хамгийн бага нь 369.3 төгрөг байв. Харин сарын эцсийн ханш 370.1 төгрөг буюу өмнөх сарынхаас өөрчлөгдөөгүй байна.


### Инфляци

2017 оны 10 дугаар сард инфляци УБ хотын хэмжээнд өмнөх сараас 0.4 хувиар өссөн байна. Үүнд хүнснээс бусад барааны үнийн өсөлт голчлон нөлөө үзүүлсэн байна. Тодруулбал, сарын өсөлтийн 0.8 нэгж хувийг хүнснээс бусад барааны үнэ, -0.5 нэгж хувийг хүнсний барааны үнэ бүрдүүлжээ. Хүнснээс бусад барааны өсөлтөд түлшний мод, нүүрс, гутлын үнийн өсөлт гол нөлөө үзүүлсэн байна. Харин хүнсний бүлгийн үнэ буурахад хонь, ямааны мах болон төмсний үнийн бууралт гол нөлөө үзүүлэв.


Зураг 12. Хадгаламжийн жигнэсэн дундаж хүү (валют)



Зураг 13. Төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн ханш



Зураг 14. Төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн ханш



Зураг 14. Улаанбаатар хотын сарын инфляци



Жилийн инфляци УБ хотын хэмжээнд тайлант сард 8.2 хувь байгаагийн 5.6 нэгж хувийг хүнснээс бусад бараа, үйлчилгээ, 2.6 нэгж хувийг хүнсний бараа, бүтээгдэхүүн бүрдүүлсэн байна.

Хүнсний бүлгийн үнэ жилийн 11.0 хувийн өсөлттэй байгаагаас хүнсний ногооны үнэ 27.5 хувиар, сүү, сүүн бүтээгдэхүүний үнэ 11.1 хувиар, мах, махан бүтээгдэхүүний үнэ 11.4 хувиар өсчээ. Харин хүнснээс бусад бараа үйлчилгээний бүлгийн үнэ жилийн 7.3 хувийн өсөлттэй байгаагаас тээвэр 10.5 хувиар, орон сууц, ус, цахилгааны үнэ 13.4 хувиар, боловсролын бүлгийн үнэ 7.5 хувиар өсчээ.

Зураг 15. Улаанбаатар хотын жилийн инфляци

